

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм,
бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны 190 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газрын дүрмийг нэгдүгээр хавсралт, бүтэц орон тоог хоёрдугаар хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажилтан, албан хаагчдыг томилох, байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн мөрдөж ажиллахыг Аялал жуулчлалын газар /Э.Баттулга/-т даалгасугай.

3. Байгууллагын бүтэц, орон тооны өөрчлөлтөөс шалтгаалан нэмэгдэх 56,768,787 /Тавин зургаан сая долоон зуун жаран найман мянга долоон зуун наян долоо/ төгрөгийг Нийслэлийн 2013 оны төсвийн тодотголын төсөлд тусгуулж батлуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2009 оны 25 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Э.БАТ-ҮҮЛ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Нийслэлийн Аялал жуулчлалын газар” /цаашид “газар” гэх/ нь нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэргэжлийн удирдлага, дэмжлэгээр хангах; нийслэл хотыг гадаад дотоодод сурталчлах чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2. Газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол болон Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллана.

1.3. Газар нь орон нутгийн төрийн захиргааны байгууллагын өөрчлөлт, хөгжилтэй уялдсан хүний нөөцийн удирдлагын арга барилыг хэрэглэн, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг үе шаттайгаар хангаж мэргэшсэн, тогтвортой, чадварлаг байлгахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

1.4. Газар нь Нийслэлийн Засаг дарга түүний орлогч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ажлаа тайлагнаж ажиллана.

1.5. Газар нь тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэж банкинд харилцах данстай байна.

Хоёр. Газрын удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

2.1. Нийслэлийн Засаг дарга нь газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоож, газрын даргыг томилж, чөлөөлнө.

2.2. Газар нь хэлтэс, алба, ахлах ажилтантай байж болно.

2.3. Газрын дарга нь Монгол Улсын Хууль тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаа явуулж, биелэлтийг нь хангуулна.

2.4. Газрын дарга нь батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

2.5. Газрын даргыг ээлжийн амралт, удаан хугацааны сургалтанд хамрагдсан, томилолт, чөлөөтэй байх үед ахлах мэргэжилтэн төлөөлөн бусад байгууллагатай харилцаж хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааг хэвийн явуулна.

2.6. Аялал жуулчлал хөгжүүлэх эрэлт хэрэгцээг харгалзан дүүргүүдэд аялал жуулчлалын асуудал эрхэлсэн нэгж /ажилтан/-ийг, гол зах зээлийн орнуудад төлөөлөгчийн газар /төлөөлөгч/ ажиллуулж болно.

2.7. Газар нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор дэргэдээ сургалт, сурталчилгаа, судалгааны ажил явуулах мэдээллийн төв ажиллуулна.

2.8. Жуулчдыг мэдээллээр хангах, сургалт, сурталчилгаа явуулах зорилгоор олон улсын байгууллагаас зөвлөх, сайн дурын ажилтан авч ажиллуулж болно.

2.9. Газар нь төсвөөс санхүүжинэ. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн сайд, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх зорилгоор Аялал жуулчлалын сангаас нэмэлт санхүүжилт авч болно.

2.10. Газрын албан хаагч бүрийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, улирлын төлөвлөгөөтэй ажиллуулж, улирлаар тайланг гаргаж, мэргэшлийн ур чадвар, үр дүнгийн гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр үнэлэн ярилцлага зохиож, зохих журмын дагуу дүгнэнэ.

Гурав. Газрын үйл ажиллагааны хамрах хүрээ, үндсэн чиглэлүүд

3.1. Хамрах хүрээ:

3.1.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчид, аялал жуулчлалтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагууд

3.2. Үндсэн чиглэлүүд:

3.2.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сайжруулах, шинээр бий болгох

3.2.2. Жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, жуулчны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

3.2.3. Улаанбаатар хотын гадаад сурталчилгааг явуулж, зорих газрын менежментийн бодлого, маркетингийн стратегийг хэрэгжүүлэх

3.2.4. Жуулчдыг татах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, аялал жуулчлалын эдийн засаг, нийгмийн нөлөөллийг зохистой хэмжээнд байлгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах

3.2.5. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх

3.2.6. Жуулчид, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад зориулсан төрөл бүрийн сургалт, судалгааны ажлууд зохион байгуулах

3.2.7. Нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх

Дөрөв. Газрын эрх, үүрэг

- 4.1. Газрын ажилд шаардлагатай мэдээ судалгаа, тайлбар, тодорхойлолт, санал дүгнэлтийг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаар өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр гаргуулна.
- 4.2. Газар эрхэлсэн ажлын чиглэлээр санал, шийдвэрийн төсөл боловсруулж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Ерөнхий менежер болон бусад холбогдох байгууллагад оруулан шийдвэр гаргуулна.
- 4.3. Гадаад дотоодын аялагч, жуулчдад үзүүлэх үйлчилгээ нь чанар, стандартын шаардлага хангахгүй байгаа аж ахуйн нэгжийн удирдлагад хариуцлага тооцох, үйл ажиллагааг нь зогсоох талаар холбогдох байгууллагуудад санал тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.
- 4.4. Аялал жуулчлалын мэдээллийн санг бүрдүүлэх чиглэлээр шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр санаачилж хэрэгжүүлэх, санхүүжилт авах эрхтэй.
- 4.5. Хариуцсан ажлын чиглэлээр, эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал шийдвэр гаргаж, биелэлтийг нь хангаж ажиллана.
- 4.6. Газар нь Улаанбаатар хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, шийдвэрийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах үүрэгтэй.
- 4.7. Нийслэлийн аялал жуулчлалын байдалд дүн шинжилгээ хийж, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх арга замыг тодорхойлж, гүйцэтгэлийг хангаж ажиллана.
- 4.8. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагыг бүртгэх, зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, бизнесийн орчныг нь сайжруулахад чиглэсэн бодлогын дэмжлэг үзүүлэх, эрх зүйн зохицуулалт хийх санал боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.9. Монгол улс, нийслэл Улаанбаатар хотыг аялал жуулчлалын зорих газар болгох, таниулахад чиглэсэн маркетинг сурталчилгааг явуулна.
- 4.10. Нийслэлийн аялал жуулчлалын нөөц, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлчилгээний байгууллагуудын талаархи судалгааг тогтмол явуулж, нэгдсэн сан бүрдүүлж ажиллана.
- 4.11. Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор өмчийн бүх хэлбэрийн байгууллагатай зохих хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж хамтран ажиллана.
- 4.12. Аялал жуулчлалын асуудлаар гадаад, дотоодод туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх сургалт семинарт мэргэжилтнүүдийг хамруулна.
- 4.13. Улаанбаатар хотод олон улсын хурал, зөвлөлгөөн, олон улс бүсийн чанартай урлаг спортын арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 4.14. Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар дэвшүүлж буй зорилт, хийж байгаа ажлынхаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулна.

4.15. Нийслэл Улаанбаатар хоттой харилцаатай хотуудтай болон бусад хотуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тухайн газруудын аялал жуулчлалын асуудал хариуцсан байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

4.16. Улаанбаатар хотод төрөлжсөн аялал жуулчлал бий болгох, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

4.17. Нийслэлийн иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс газрын эрхлэх ажил үүрэгтэй холбогдсон асуудлаар ирсэн санал, хүсэлт, гомдлыг судалж, холбогдох байгууллагуудтай хамтран зохих хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Тав. Хариуцлага

5.1 Газрын дарга нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж байгууллагадаа хохирол учруулсан бол уг хохирлыг бүрэн хариуцна.

5.2 Газрын дарга нь хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх явцад буруу алдаатай шийдвэр гаргаж, бусдад хохирол учруулсан бол зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3 Газрын албан хаагчид нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журам, үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээг зөрчсөн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.4 Хууль, тогтоомж зөрчсөн албан хаагчдад эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.5 Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан албан хаагчид эд хөрөнгийг нөхөн төлнө.

Зургаа. Бусад зүйл

6.1. Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

6.2. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

6.3. Хуульд нийцүүлэн энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.

..... оОо

Нийслэлийн Засаг даргын 20... оны ...
дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн ... хавсралт

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
БҮТЭЦ, ОРОН ТОО

д/д	Нэр	Хэлтэс алба	Орон тоо
1	Нийслэлийн Аялал жуулчлалын газар	-	18 хүртэл, үүнээс дарга 1,

